



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 11

Өмнөдэлгэр сум

**Хоршоо хөгжүүлэх сангийн тэргүүлэх
чиглэлийг тодорхойлж батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Хоёрдугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Өмнөдэлгэр суманд 2025 онд Хоршоо Хөгжүүлэх Сангийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж хавсралтаар баталсугай.


2.Тэргүүлэх чиглэлийн ажлуудыг дэмжин ажиллаж бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга (Р.Энхтөр)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн
Хоёрдугаар хуралдааны 11 дүгээр
тогтоолын хавсралт



2025 ОНЫ ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

1.ХАА-Н ЧИГЛЭЛЭЭР

- Тахиа, шувуу, зөгий, гахайн туслах аж ахуйг хөгжүүлэх
- Зоорь барих /Өөрөө ногоо тариалдаг байх ба 10тн-оос дээш багтаамжтай байна/
- Малын хадлан тэжээл, ургамал тариалалт, дарш бэлтгэх
- Дайвар бүтээгдэхүүн боловсруулах
- Хүлэмжийн аж ахуй, Жимс жимсгэний аж ахуй
- Төмс хүнсний ногоо тариалах
- Мод үржүүлэх
- Мал аж ахуйн фермэр, ферм

2.ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

- Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл /хиам болон лаазалсан, утсан зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэл/
- Хүнсний ногоо боловсруулах /Савлах, даршлах/
- Сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах
- Гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл

3.ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

- Эсгий, ноос ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- Хог хаягдал дахин боловсруулах
- Арьс шир боловсруулах үйлдвэрлэл
- Сийлбэр, тавилга болон мод модон бүтээгдэхүүн
- Аялал жуулчлал, Аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэх /Арьс ширэн эдлэл, бэлэг дурсгал, гар урлалын бүтээл хийх/

4.НИЙТИЙН АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

- Оёдол, сүлжмэлийн үйлдвэрлэл
- Авто засвар, цахилгаан хэрэгсэлийн засвар
- Гутал засвар, үйлдвэрлэл
- Нийтийн хоол
- Авто угаалга
- Нийтийн хувцас угаалгын газар
- Халуун усны үйлчилгээ (саун)
- Үсчин, гоо сайхан